



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/10.

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2024 оны “Зөвшөөрөл олгох тухай” 215 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Ахлах нягтлан бодогч, хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг нэгдүгээр, Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын байцаагч, мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар, Хамралт, орлого, цахим үйлчилгээ хариуцсан байцаагч, мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг гуравдугаар, Сургалт сурталчилгаа, архив, дотоод асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (А.Мөнхцэцэг)-д даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2020 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/14 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА